



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 01-Р УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 04-р сарын 08-ны өдөр

Орхон аймаг

Нэг. Хяналтын үндэслэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02/529 тоот албан даалгаврын дагуу Шилэн дансны тухай хууль тогтоомж, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” үндэслэнэ.

Хоёр. Хяналтын зорилго

Шилэн дансны цахим хуудасны Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл 2025 оны 01-р улирлын хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд хяналт хийж, зөрчлийг арилгуулахад зорилго оршино.

Гурав. Хяналтын хамрах хүрээ

Шалгалтыг 2025 оны 01-р улирлын Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд хугацаанд Нийгмийн даатгалын газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Г.Галбадрах шалгалтыг хийж гүйцэтгэн ажилласан.

Дөрөв. Шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал

- Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 4, хугацаа хоцроож мэдээлсэн 1, мэдээлээгүй 129 байна
- Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 39 ба мэдээлээгүй 120 байна.

Тав. Хяналтын үр дүн

Үйл ажиллагааны мэдээлэл оруулахдаа:

- Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайлангаа оруулсан.
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн цэсэд мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаалуудыг бүрэн байршуулаагүй.



- Байгууллагын батлагдсан төсвийг 2025 оны 01-р сарын 23-ны өдөр байршуулсан нь дээд газраас хугацаа хоцроож ирсэнтэй холбоотойгоор 1 мэдээ хоцроож мэдээлсэн байна.

Сангийн мэдээллийн оруулахдаа:

- Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайлангаа оруулсан.

Зургаа. Шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой илэрсэн зөрчил

Үйл ажиллагааны шилэн дансны дансны мэдээлэлд:

- 1.Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан.
- 2.Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг оруулаагүй тайлагнасан.
3. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн цэсэд мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаалуудыг дутуу байршуулсан.

Сангийн шилэн дансны дансны мэдээлэлд:

1. Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан.

Долоо. Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулгыг харгалзах оруулах мэдээлэл байхгүй үед шалтгааныг нь тайлбарлан бичиж, дарааллын дагуу бүх цэсийг бүрэн дарж баталгаажуулах, мэдээ оруулах хуулийн хугацааг өдөр бүр орж шалгаж хэвших, хэмнэлт хэтрэлтийн тайлбарыг бүрэн гүйцэт бичиж оруулах, тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулах, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг нягтлан бодогчид 7 хоногийн дотор өгч хэвшиж, хавсралт цэстэй байгаа мэдээлэлд хавсралтыг оруулж цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Найм. Дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу төсвийн байгууллага үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 330 мэдээллээс нэгдүгээр улиралд бүр, сар, улирал, эхний хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс хуулийн хугацаанд 80 мэдээллийг байршуулан, 1 мэдээллийг хоцроож тайлагнасан ба тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулаагүй хугацаа хоцроож, тухайн сардаа багтаан оруулж ажиллаж байна.

Ес. Цаашид авах арга хэмжээний санал

- 1.Цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах





2.Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах сургалтыг мэргэжлийн болон дээд шатны байгууллагаас авах

3.Цаашид мэдээлэл хоцроохгүй байхад чиглэсэн арга хэмжээ, зохион байгуулалт хийж ажиллах

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

